



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХАРИЛЦАН ХӨХҮҮЛЭН ДЭМЖИХ,
ХАМГААЛАХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэж нэрлэнэ/,

хоёр Улс, тэдгээрийн ард түмний хоорондын нөхөрсөг болон хамтын ажиллагааны харилцааг харгалзан,

Нэг Улсын хөрөнгө оруулагчаас нөгөө Улсын нутагт эрх тэгш, харилцан ашигтай байх үндсэн дээр хөрөнгө оруулах явдлыг дэмжих, тааламжтай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэн,

энэхүү Хэлэлцээрийн дагуу хөрөнгө оруулалтыг харилцан хөхүүлэн дэмжих, хамгаалах нь энэ салбарт ажил хэрэгч санаачилгыг урамшуулна гэдгийг хүлээн зөвшөөрч,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Нэр томъёо

Энэхүү Хэлэлцээрт:

I. "Хөрөнгө оруулалт" гэдэгт мөнгөөр үнэлж болох бүх төрлийн эд хөрөнгө, түүний дотор дараах зүйлийг багтаана:

а/хөдлөх ба үл хөдлөх өмч, өмчийн аливаа эрх, түүний дотор үл хөдлөх хөрөнгийн дэнчин, саатуулан барьцаалах эрх буюу барьцаа;

б/пүүсүүдийн хувьцаа, үнэт цаас, облигаци буюу тэдгээр пүүсийн өмч хөрөнгийн эзэмшлийн эрх;

в/мөнгө олгосноос буку эдийн засгийн хувьд үнэ цэнэ бүхий аливаа контрактыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас үүдэн гарах нэхэмжлэл;

г/үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн эрх, түүний дотор зохиогчдын эрх, патент, бэрааны тэмдэг, пүүсийн нэр, үйлдвэрлэлийн дизайн, худалдааны нууц, техникийн процесс, ноухау, пүүсийн нэр хүнд;

д/хууль эсхүл гэрээний дагуу аж ахуйн үйл ажиллагаа явуулахад шаардагдах эдийн засгийн хувьд үнэ цэнэ бүхий зөвшөөрөл, түүний дотор байгалийн нөөцийг эрж хайх, олборлох, боловсруулж ашиглах зөвшөөрөл;

Хөрөнгө оруулалтын хэлбэрийн аливаа өөрчлөлт нь "Хөрөнгө оруулалт" гэдэг тодорхойлолтыг үл хөндөнө.

2."Орлого" гэдэгт хөрөнгө оруулалтын үр дүнд олсон орлого, ялангуяа ашиг, хүү, ногдол ашиг, төлбөр, үйлчилгээний хөлс буку өдөр тутмын бусад орлого багтах бөгөөд гэхдээ орлого нь зөвхөн эдгээрээр үл хязгаарлагдана.

3."Хөрөнгө оруулагч" гэж Хэлэлцэн тохирогч аль аль Талын хувьд:

а/Хэлэлцэн тохирогч тухайн Талын хууль тогтоомжийн дагуу уг Талд харьяалагддаг иргэн хүн;

б/Хэлэлцэн тохирогч тухайн Талын хууль тогтоомжийн дагуу үүссэн буку байгуулагдсан аливаа компани, фирм, байгууллага, нийгэмлэгийг хэлнэ.

Гэхдээ дээр дурдсан иргэн хүн, компани, фирм, байгууллага, нийгэмлэгүүд нь тухайн Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн



3.

дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт хөрөнгө оруулах эрх бүхий этгээд байвал зохино;

4. "Нутаг дэвсгэр" гэж

а/Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хувьд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүрэн эрх буюу хууль үйлчлэх нутаг дэвсгэр;

б/Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд Бүгд Найрамдах Солонгос Улсын бүрэн эрх буюу хууль үйлчлэх нутаг дэвсгэрийг нэрлэнэ.

5. "Чөлөөтэй хөрвөх валют" гэж олон улсын худалдааны төлбөрт болон олон улсын валютын гол зах зээлийн гүйлгээнд түгээмэл хэрэглэдэг валютыг нэрлэнэ.

Хоёрдугаар зүйл

Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих,
хамгаалах

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулахыг хөхүүлэн дэмжих, таатай нөхцөл бүрдүүлэх бөгөөд тийнхүү хөрөнгө оруулахыг өөрийн хууль, тогтоомжийн дагуу зөвшөөрнө.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалтад ямагт шударга, эрх тэгшээр хандах бөгөөд түүнийг бүрэн хамгаалж, аюулгүй байдлыг нь хангана.

Гуравдугаар зүйл

Үндэсний болон нэн тааламжтай
Үндэстний нөхцөл

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө

оруулалтад болон түүнээс олох орлогод шударга, эрх тэгш горим эдлүүлэх бөгөөд тэр нь нөгөө Талын болон аливаа гуравдагч орны хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад болон орлогод олгодог нөхцөлөөс дутуугүй тааламжтай байна.

2.Хэлэлцэн тохирогч аль аль Тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа эрхлэн хөтлөх, ашиглах, хэрэглэх, зарцуулахад нь шударга, эрх тэгш горимыг өөрийн нутагт эдлүүлэх бөгөөд тэр нь өөрийн орны болон аливаа гуравдагч орны хөрөнгө оруулагчдад олгодог горимоос дутуугүй тааламжтай байна.

Дөрөвдүгээр зүйл

Хохирлыг нөхөн төлөх

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хийсэн хөрөнгө оруулалтад дайн, зэвсэгт мөргөлдөөн, онц байдал буюу тэдгээртэй адилтгах бусад нөхцөл байдлын улмаас хохирол учирсан байвал уг хохирлыг нөхөн төлөх буюу бусад хэлбэрээр зохицуулахдаа Хэлэлцэн тохирогч нөгөө Тал өөрийн орны болон аливаа гуравдагч орны хөрөнгө оруулагчдад олгодог дутуугүй тааламжтай горимыг эдлүүлнэ.Энэхүү зүйлийн дагуу хийх аливаа төлбөрийг чөлөөтэй гуйвуулж болно.

Тавдугаар зүйл

Хөрөнгийг албадан хураах

1.Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчдаас хийсэн хөрөнгө оруулалтыг бүх нийтийн зорилгоос бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр улсын өмч болгох, албадан хураах буюу тэдгээртэй адилтгах арга хэмжээ /цаашид "албадан хураах" гэж нэрлэх/ авахгүй.Албадан хураалт нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үндсэн дээр хууль зүйн ёс журмын дагуу явагдах бөгөөд тэр нь нөхөн төлөг-

дөнө.

2. Албадан хураасан хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх хэмжээ нь түүнийг албадан хураахаас өмнөхөн буюу албадан хураах талаар нийтэд мэдэгдэхийн өмнө байсан зах зээлийн үнэтэй тэнцүү байхаас гадна мөн түүний хууг хураагдсан өдрөөс нь эхлэн тооцож багтаасан байвал зохих бөгөөд төлбөрийг чөлөөтэй гуйвуулна. Нөхөн төлөх явдлыг үр ашигтай, бүрэн хэмжээгээр, зүй бусын сааталгүйгээр гүйцэтгэвэл зохино.

3. Хөрөнгө оруулалтаа албадан хураалгасан хөрөнгө оруулагч нь энэ зүйлд заасан зарчмын дагуу өөрийн хэргийг болон хөрөнгө оруулалтын үнэлгээг хөрөнгийг хураасан Хэлэлцэн тохирогч Талын шүүхийн буюу холбогдох бусад байгууллагаар нэн даруй хянуулах эрхийг албадан хураасан Хэлэлцэн тохирогч Талын хуулийн дагуу эдлэнэ.

4. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь түүний нутаг дэвсгэрийн тухайн хэсэгт мөрдөж буй хуулийн дагуу нэгдэж үүссэн буюу байгуулагдсан бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшиж байгаа компанийн эд хөрөнгийг албадан хураахдаа энэхүү зүйлийн I-ийн заалтуудыг мөрдлөгө болгоно.

Зургадугаар зүйл

Хөрөнгө оруулалт, орлогыг эгүүлэн буцаах

I. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтынх нь хувьд дор дурдсан зүйлсийг чөлөөт валютаар гуйвуулах баталгаа өгнө:

а/цэвэр ашиг, ногдох ашиг, төлбөр, техникийн туслалцаа болон техникийн гүйлчилгээний хөлс, хүү болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулсны үр дүнд олсон өдөр тутмын бусад орлого;



6.

б/Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн аливаа хөрөнгө оруулалтыг худалдсанаас эсхүл бүхэлд нь буку хэсэгчлэн татан буулгаснаас бий болсон ашиг;

в/Зээлийн төлбөрт өгөх хөрөнгө мөнгө;

г/Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хөрөнгө оруулсантай холбогдуулан тэнд ажиллах байгаа уг Талын иргэдийн цалингийн зохих хувь;

д/Хэлэлцэн тохирогч нөгөө Талын буку гуравдагч орны нутаг дэвсгэрт оруулсан хөрөнгө оруулалтыг удирдахад зарцуулсан хөрөнгө мөнгө;

е/Хөрөнгө оруулалтын хэвийн ажиллагааг хангахад шаардагдах нэмэлт хөрөнгө.

2.Энэхүү зүйлийн I-д заасан амгийг чөлөөт валютаар гуйвуулахдаа тэр валют нь хөрөнгө оруулалт болон түүний орлогоор бий болсон нөхцөлд л гуйвуулж болно.

3.Хөрөнгө оруулагч хүлээсэн хууль ёсны үүргээ гүйцэтгэсэн нөхцөлд Хэлэлцэн тохирогч аль аль Тал нь энэ зүйлийн I-д заасан гуйвуулгыг саадгүй хийхэд шаардагдах арга хэмжээ авна.

4.Энэхүү Хэлэлцээрийн хувьд нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалт хийсэн Хэлэлцэн тохирогч Талд хүчин төгөлдөр үйлчилж байгаа солилцооны журмын дагуу гуйвуулагдсан бөгөөд гуйвуулга хийсэн тухайн өдөр мөрдөж байгаа ханшийг валютын солилцооны ханшаар авна.

Долдугаар зүйл

Тусгай зээлтүүд

Хэлэлцэн тохирогч аль аль Талын, эсхүл гуравдагч орны хөрөнгө оруулагчдад олгогдсоос дутуугүй тааламжтай нөхцөл олгож

байх тухай энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг Хэлэлцэн тохирогч аль нэг Тал дор дурдсан тохиолдолд олгосон аливаа таатай нөхцөл, хөнгөлөлт, давуутай эрхийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдад мөн олгох үүргийг Хэлэлцэн тохирогч эхний Тал хүлээн мэтээр тайлбарлахгүй.

а/Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь нэгдэн орсон буюу нэгдэх боломжтой одоо байгаа хийгээд цаашид бий болох гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүс, нэгдсэн тарифын бүс, валютын холбоо, эсхүл тэдгээртэй адилтгах олон улсын хэлэлцээр буюу бүсийн хамтын ажиллагааны бусад байгууллага;

б/татварын асуудалд бүхэлдээ буюу голлон хамаарагдах олон улсын аливаа хэлэлцээр эсхүл дотоодын хууль тогтоомж.

Наймдугаар зүйл

Эрхийг шилжүүлэх

1.Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал, түүний томилсон байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оруулсан хөрөнгө оруулалт буюу түүний зохих хэсгийн хувьд хийсэн даатгалын дагуу өөрийн хөрөнгө оруулагчид төлбөр хийвэл сүүлийн Хэлэлцэн тохирогч Тал:

а/уг хөрөнгө оруулагчаас аливаа эрх, нэхэмжлэлээ хууль тогтоомж болон хууль ёсны хэлцлийн дагуу Хэлэлцэн тохирогч өөрийн Талд буюу түүний томилсон байгууллагад шилжүүлснийг;

б/эрх ийнхүү шилжсэний дагуу Хэлэлцэн тохирогч тухайн Тал буюу түүний томилсон байгууллага дээрх хөрөнгө оруулагчийн эрхийг эдэлж, нэхэмжлэлийг нь биелүүлэх болсныг тус тус хүлээн зөвшөөрнө.

2.Иймд эрхийг шилжүүлэн авсан Хэлэлцэн тохирогч Тал буюу түүний томилсон байгууллага нь хэрэв хүсвэл хөрөнгө оруулагчийн

эрх, нэхэмжлэлийг түүний эдэлж байсан тэр хэмжээгээр эдлэх эрхтэй.

3.Эрхийг шилжүүлэн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь энэхүү зүйлийн дагуу мөнгөн орлогыг хууль ёсны валютаар олж авбал уг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр гарсан зардлаа нөхөх зорилгоор дээрх мөнгөн орлогыг чөлөөтэй ашиглана.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал болон
Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө
оруулагчийн хооронд хөрөнгө оруулалтын
асуудлаар гарсан маргааныг шийдвэрлэх

1.Хэлэлцэн тохирогч аль нэг Тал болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хооронд үүссэн аливаа маргаан, түүний дотор хөрөнгө оруулалтыг албадан хураах, улсын өмчлөлд авахтай холбогдсон маргааныг маргаанд оролцогч Талууд аль болох эв зүйгээр шийдвэрлэнэ.

2.Нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалт хийсэн Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль тогтоомжид заасан хууль зүйн хэрэгслийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчид ашиглуулах бөгөөд чингэхдээ өөрийн хөрөнгө оруулагчдын буюу аливаа гуравлагч улсын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад олгогдоос дутуугүй тааламжтай нөхцөлөөр, гэхдээ энэ хоёроос тухайн хөрөнгө оруулагчид аль илүү тааламжтайг нь ашиглуулна.

3.Хэрэв аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэх талаар Хэлэлцэн тохирогч аль нэг Талаас санал гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор шийдвэрлэж чадаагүй бөгөөд Бүгд Найрамдах Монгол Ард Улс дор дурдсан Конвенцийн гишүүн болсон нөхцөлд хөрөнгө оруулагч эсхүл Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр түүнийг "Улс орон болон нөгөө улс орны иргэдийн хооронд хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай" 1965.3.18-ны өдрийн Вашингтоны Конвенцийн дагуу байгуулсан хөрөнгө оруулалтын та-



9.

лаарх маргааныг шийдвэрлэх Олон улсын Төвд шилжүүлнэ. Маргааныг дээр дурдсан Төвд шилжүүлэхийн өмнө түүнийг Вашингтоны Конвенцийг үндэслэн харилцан тохиролцон эвлэрүүлэгчид болон арбитрт мөн оруулна.

4. Аль аль тал эрхэмлэн үзэж өөрсдийн онцгой шаардлагад хамгийн тохиромжтой хэмээн зөвшөөрсөн арбитрын буюу маргаан шийдвэрлэх бусад аливаа хэлбэрийг маргаанд оролцогч Талууд сонгон тохиролцоход хориг саад тавьж байгаа мэтээр Хэлэлцээрийн энэхүү зүйлийг тайлбарлахгүй.

Аравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын хоорондын
маргааныг шийдвэрлэх

1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд үүссэн маргааныг бололцоотой бол дипломат цугаамаар шийдвэрлэнэ.

2. Хэрэв Хэлэлцэн тохирогч Талууд маргааныг 6 сарын дотор шийдвэрлэж чадахгүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр Хөндлөнгийн шүүхэд шилжүүлнэ.

3. Хөндлөнгийн шүүхийг маргаан үүсэх бүрт дор дурдсан журмаар байгуулна:

Маргааныг шүүхэд шилжүүлэх хүсэлт гаргаснаас хойш 2 сарын дотор Хэлэлцэн тохирогч Тал тус бүр шүүхийн нэг нэг гишүүнийг томилно. Томилогдсон гишүүд улмаар аль нэгэн гуравдагч орны иргэнийг сонгох бөгөөд тэр нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын зөвшөөрөөр Шүүхийн даргаар томилогдоно. Шүүхийн хоёр гишүүн томилогдсоноос хойш 2 сарын дотор Шүүхийн даргыг томилно.

4. Энэхүү зүйлийн 3-д заасан хугацаанд шүүхийн зохих бүрэлдэхүүнийг томилоогүй бөгөөд Талууд өөрөөр тохиролцоогүй бол

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь Хөндлөнгийн шүүхийн бүрэлдэхүүнийг томилуулахаар Олон улсын Шүүхийн даргыг урьж болно. Олон улсын Шүүхийн дарга нь Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн буюу мөн тэр нь энэ үүргийг бусад ямар нэг шалтгаанаар гүйцэтгэх боломжгүй бол зохих томилолтыг хийлгүүлэхээр Олон улсын Шүүхийн дэд даргыг урина. Хэрэв энэ дэд дарга нь мөн Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн буюу дээр дурдсан үүргийг мөн биелүүлэх боломжгүй бол дэд даргын дараах тухаалын Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн бийш гишүүнийг шаардлагатай томилолт хийлгэхээр урина.

5. Хөндлөнгийн шүүх шийдвэрээ олонхийн саналаар гаргана. Шүүхийн шийдвэрийг Хэлэлцэн тохирогч Тал тус бүр шүүхийн бүрэлдэхүүн дэх өөрийн гишүүний болон шүүхийн ажиллагаанд өөрийгөө төлөөлүүлсний зардлыг хариуцна. Шүүхийн даргын болон бусад зардлыг Хэлэлцэн тохирогч Талууд тэнцүү хэмжээгээр хариуцна. Гэвч шүүх нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль нэгд зардлын ихэнх хэсгийг ногдуулахаар өөрийн шийдвэрт зааж болох бөгөөд энэхүү шийдвэрийг Хэлэлцэн тохирогч хоёр Тал заавал биелүүлэх ёстой. Шүүх нь шүүн таслах ажиллагааны дэгийг өөрөө тогтооно.

Арван нэгдүгээр зүйл

Хэлэлцээрийг хэрэглэх нь

Энэхүү Хэлэлцээр нь түүний хүчин төгөлдөр болохоос өмнө буюу хойно оруулсан бүх хөрөнгө оруулалтад хамаарах боловч уг Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө хөрөнгө оруулалтын талаар гарч шийдвэрлэгдсэн аливаа маргаан буюу нэхэмжлэлд хамаарахгүй.

Арван хоёрдугаар зүйл

Хэлэлцээр хүчин төгөлдөр болох, хүчинтэй байх хугацаа, түүнийг хүчингүй болгох

1. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Тал тус бүр түүнийг хүчинтэй болгох талаар хууль зүйн бүхий л шаардлагыг биелүүлсэн тухайгаа харилцан мэдэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр



II.

болно.

2. Энэхүү Хэлэлцээр нь 10 жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд түүнийг Хэлэлцэн тохирогч аль нэг Тал цуцлах тухайгаа 6 сарын өмнө бичгээр мэдэгдээгүй бол цаашид ч хүчин төгөлдөр хэвээр байна.

3. Энэхүү Хэлэлцээрийг харилцан тохиролцсоны үндсэн дээр хянан өөрчилж болно. Хэлэлцээрийг хянан өөрчлөх буюу цуцлах нь уг өөрчлөлт, цуцлалт хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө энэхүү Хэлэлцээрийн дагуу үүссэн эрх, хүлээсэн үүргийг хөндөхгүй.

Дээр дурдсаныг нотлон тус тусын Засгийн газраас зохих ёсоор эрх олгосноор дор дурдсан хүмүүс энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хэлэлцээрийг 1991 оны 3 дугаар сарын 28 өдөр Сеул хотноо тус бүр монгол, солонгос, англи хэлээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлахад санал зөрвөл англи хэл дээрх эх хувийг баримтална.

БҮГД НАЙРАМЛАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

БҮГД НАЙРАМЛАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС